



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 2/119

Хэрлэн сум

Тусгай зөвшөөрлийг цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.2, 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тусгай зөвшөөрлийн төлбөрийг хуулийн хугацаанд төлөөгүй, хайгуулын үйл ажиллагааны тайлан гүйцэтгэлийг зөвшөөрсөн хугацаанд ирүүлээгүй “Өндөрхаан тохижилтын газар” ОНТҮГ-ын Мөрөн, Хэрлэн сумдын нутаг дахь Хэрлэн нэртэй 101.09 га талбай бүхий XV-23000071 дугаартай Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг цуцалсугай.

2. Тусгай зөвшөөрөл цуцалсан тухай шийдвэрийг аймгийн Байгаль, орчин аялал жуулчлалын газар, Цагдаагийн газар, Мөрөн, Хэрлэн сумдын Засаг дарга нарт тус тус мэдэгдэж, Ашигт малтмал, газрын тосны газрын кадастрын зураг зүйн нэгдсэн бүртгэлд бүртгэхийг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Э.Мөнх-Эрдэнэ)-т даалгасугай.

3. Хайгуулын ажил хийгдсэн талбайд тухайн тусгай зөвшөөрөл эзэмшиж байсан аж ахуйн нэгж компаниар нөхөн сэргээлт хийлгүүлж, байгаль орчны хохирлыг барагдуулах арга хэмжээ авч ажиллахыг Мөрөн сумын Засаг дарга (Ц.Батцоож), Хэрлэн сумын Засаг дарга (М.Шүрэнцэцэг) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ

